



---

## **ADMISSIONS POLICY**

---

DATE DOCUMENT PUBLISHED: **APRIL 2022**

APPROVAL BY: **HEAD OF SCHOOL**

APPROVAL DATE: **APRIL 2022**

DOCUMENT OWNER: **HEAD OF SCHOOL**

DATE FOR REVIEW: **NOVEMBER 2024**

REVIEWER: **IRMUUN BAYASGALAN**

REVIEW HISTORY: **MODIFIED IN NOVEMBER 2023**

## ЭЛСЭЛТИЙН БОДЛОГО

“Хүүхэд бүрд сурах чадвар, нөөц бий” гэсэн итгэл үнэмшлийнхээ дагуу Олонлог академийг сонгон бидэнд итгэл хүлээлгэсэн хүн бүрд бидний үүд хаалга нээлттэй байх болно. Элсэлтийн цорын ганц хязгаарлах хүчин зүйл нь барилга байгууламжийн багтаамж, хүчин чадал байна.

Бид өөрсдийн боловсруулсан сургалтын хөтөлбөрийн онцлогт тохирсон хүүхдийн түвшин тогтоо шалгалтыг элсэлтийн үеэр сургач бүрээс авдаг бөгөөд энэ нь анги хуваарилах, нэмэлт давтлага, сургалтын хэрэгцээг тодорхойлох зорилготой.

Хүүхдийн яс үндэс, хэл соёл, итгэл үнэмшил, нийгмийн гарал үүсэл, хүйс, эрүүл мэндийн аливаа нөхцөл байдал нь хүүхдийг элсүүлэхээс татгалзах үндэслэл болохгүй.

### IB DP ХӨТӨЛБӨРИЙН ЭЛСЭЛТИЙН БОДЛОГО

IBDP хөтөлбөр нь сургчаас багагүй хүчин чармайлт, ачаалал даах чадвар, туштай байдлыг шаарддаг тул хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд элсэгчид тодорхой шаардлагуудыг хангасан байх хэрэгтэй.

Үүнд академик мэдлэгээс гадна сэтгэлзүй суурь бэлтгэл, хувь хүний зохион байгуулалт, хүсэл тэмүүлэл чухал.

## ADMISSIONS POLICY

Our doors will be open to anyone who chooses Olonlog Academy, in line with our belief that “every child has the ability and resources to learn”. The only limiting factor in admission is the capacity of the facility and space.

We take a level-based test from each student at the time of enrollment, tailored to the specifics of the curriculum we have developed, to determine class allocation, additional rehearsals, and learning needs.

A child's ethnicity, language, culture, beliefs, social origin, sex, or health status shall not be grounds for refusing to enrol a child.

### ADMISSION POLICY FOR IB DP PROGRAM

Due to the fact that IB DP program requires substantial effort, resilience, and perseverance from the students, entrants must meet certain requirements for entrance of the programme and to ensure successful completion of IB.

In addition to academic knowledge, basic psychological development, personal management and passion are important.



Иймд IBDP хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 10-р ангийн сургчид хөрвөх сургалтад хамрагдах бөгөөд элсэлтийн шалгалтаар тус хөтөлбөрт элсүүлнэ.

Шалгалтаар DP хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан гаднын болон дотоод сургчид зэрэгцэн өрсөлдөж сонгон шалгаруулалт явуулна. Сонгон шалгаруулалтад тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг жил бүр удирдамжаар гаргана.

Therefore, 10th graders who wish to enrol in the IBDP program will be required to take a transition course and be admitted to the program through an entrance examination.

External and internal students applying for the DP program will be selected at the same time. Requirements and criteria for selection will be set out in the guidelines on an annual basis.

## IB DP ХӨТӨЛБӨРТ ЭЛСЭГЧДЭД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

### Өмнөх амжилт:

1. Академик амжилт /өмнөх хугацааны сурлагын дүн/
2. Хариуцсан ажилласан багшийн тодорхойлолт /ёс зүйн тухай түлхүү/
3. Нийгмийн идэвх санаачилга

### Шалгалтаар:

1. Математик – Шалгалтын оноогоор уралдана.
2. Англи хэл - B2 буюу IELTS 5 – 5.5 түвшний шалгалтын оноогоор уралдана
3. Эх хэл – Шалгалтын оноогоор уралдана.

### Ярилцлагаар:

1. Хувь хүний хүсэл тэмүүлэл, хандлага
2. Цаашид амжилттай суралцах магадлал

## GENERAL REQUIREMENTS FOR IB DP CANDIDATES

### Previous achievements:

1. Academic achievement / previous academic results /
2. Recommendation letter by the teacher in charge
3. Social initiatives

### By examination:

1. Mathematics - Compete with test scores
2. English - B2 or IELTS 5 - 5.5 level test scores
3. Mother tongue - Competitive test scores

### By interview:

1. Individual aspirations and attitudes
2. Probability of further successful study



## ЭЛСЭЛТИЙН БОДЛОГО БА ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Олонлогийн Академи нь Олон улсын бакалаврын дипломын хөтөлбөрт (IBDP) элсэн суралцаж буй сурагчдын олон төрлийн хэрэгцээг харгалзан үзэж, хүртээмжтэй, дэмжлэг үзүүлэх сургалтын орчинг бүрдүүлэхийг зорьж байна. Тусгай боловсролын хэрэгцээ (SEN) эсвэл суралцах бэрхшээлтэй (SpLD) элсэгчдэд тавигдах нэмэлт нөхцөл, шаардлага байхгүй.

Гэсэн хэдий ч Олонлог академид элссэн сурагч бүр Хүртээмжтэй байдлын бодлогын үр шимийг бүрэн хүртэхийн тулд эцэг эх/хууль ёсны асран хамгаалагч(үүд) нь сургуулийн IBDP-д суралцах өргөдөл гаргах явцдаа ангийн багш, нийгмийн ажилтнуудад шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж өгнө.

### ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫН БОДЛОГЫН ТУХАЙ

Олонлог академи нь IB-ын эрхэм зорилгод нийцүүлэн сурагчдын олон талт байдлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэдэг. Сурагч бүр суралцах боломжтой бөгөөд амжилттай, бие даасан, насан туршдаа суралцагч болоход нь туслахын тулд шаардлагатай үр чадвар, тохируулгыг суралцахуйд нь хийх ёстой гэдэгт бид итгэдэг. Иймд бид сургуулийн чадавхид нийцүүлэн шаардлагатай нөөц, зааварчилгаа, бусад боломжоор хангахыг эрмэлзэж, бүх сурагчид, тэр дундаа боловсролын тусгай хэрэгцээ (SEN) эсвэл суралцах бэрхшээлтэй (SpLD) сурагчдад сургуулийн IBDP хөтөлбөрт суралцахад нь тэгш хандахыг эрмэлздэг.

### INCLUSION POLICY AND ADMISSION

In recognition of the diverse needs of our student body, including those enrolled in the International Baccalaureate Diploma Programme (IBDP), Olonlog Academy is committed to fostering an inclusive and supportive learning environment. There is no additional admission conditions and requirements for students with Special Educational Need (SEN) or a Specific Learning Difficulty (SpLD).

However, in order to ensure that every student enrolled at Olonlog Academy receives the full benefits of the Inclusion policy, parents/legal guardian(s) need to provide the necessary documentation to homeroom teachers and social learning staff during the application period to the school's IBDP.

### INCLUSION POLICY OVERVIEW

Consistent with the IB Mission Statement, Olonlog Academy recognizes and respects the diversity of students. We believe that every student can learn and should be provided with the necessary skills and adjustments to learning to help them become successful, independent, and lifelong learners. Hence, we strive to provide the resources needed, guidance, differentiations, and accommodation within the school's capability so that all students, including the students with Special Educational Need (SEN) or a Specific Learning Difficulty (SpLD), have equal and meaningful access to the school's IBDP programme.

